



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/83

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 42.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арга хэмжээ"-ний зардлаас Ахмадын холбооны нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 3,898,000 (гурван сая найман зуун ерэн найман мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Арга хэмжээний төсвийн дагуу 3,898,000 (гурван сая найман зуун ерэн найман мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг Нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3. Худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4. Арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг чанартай удирдан зохион байгуулж, тайлагнан ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д, хөрөнгө ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргүүн (А.Эрдэнэчулуун), Ахмадын холбооны тэргүүн (Д.Гэрэлмягмар) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

2023 оны 05-р сарын 29-ны өдрийн
 1163 дугаар захирамжийн хавсралт



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Хөрөнгийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хариуцах байгууллага
1	Дуу өсгөгч	Олон залгуур ордог.	1	550,000	550,000	Ахмадын холбоо
2	Телвизор	65инч	1	1.399.000	1.399.000	
3	Дуу өсгөгч	Олон залгуур ордог.	1	550,000	550,000	ХБИ холбоо
4	Телвизор	65инч	1	1.399.000	1.399.000	
Нийт үнэ					3.898.000	

ТӨСӨВ ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН:

Б.АЛТАНСҮХ